

25
7

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөл ба
Монгол Ардын Хувьсгалт Намын
Төв Хорооны

ТОГТООЛ

1954 оны 9 дугаар
сарын 6 ны өдөр

дугаар 463/УБ

Улаанбаатар
аот

Улсын ба хоршооллын худалдааг
хөгжүүлэн сайжруулах арга
хэмжээний тухай

1954 оны турш нам, засгаас ардын аж ахуй, соёлыг цаашид хөгжүүлж, хөдөлмөрчдийн амьдралын хэмжээг дээшлүүлэхэд чиглэгдсэн нэн чухал арга хэмжээнүүдийг авчээ.

Мал аж ахуйн үйлдэхүүнийг улсад албан журмаар нийлүүлэх шинэ системийг журамлаж, мал ба мал аж ахуйн үйлдэхүүнийг бэлтгэх ба худалдан авах үнийг нэмэгдүүлэн, ардын хэрэгцээт чухал барааны улсын жижиглэн худалдаалах үнийг хямдруулаад, улсад албан журмаар нийлүүлэх зүйл ба мал аж ахуйн албан татварын дутууг хасах, мал аж ахуйн албан татварын шинэ хуулийг гарган, ард түмэнд зориулсан барааны фондын хэмжээг нэмэгдүүлсэн энэ бүх зүйл бол ард түмний материалэг сайн сайхан байдлыг гуйвалтгүй дээшлүүлэхийн төлөө нам, засгаас байнга санаачлаж байдгийн шинэ тод гэрч мөн.

Нам, Засгийн энэ санаачлагыг практик дээр нь биелүүлэх явдалд ард түмний байнга өсөж байгаа эрэлт хүсэлтийг аж үйлдвэрийн ба хүнсний бараагаар эрхэм сайнаар хангах үүрэгтэй улсын ба хоршооллын худалдааны ажил онц чухал ач холбогдолтой юм. Гэтэл улсын ба хоршооллын худалдааны байгууллагууд, еерсдийн ажлыг удаанаар еерчлэн зохиож, нам, засгаас худалдааны талаар тавьсан зорилтуудыг биелүүлэхэд шаардагдах бүх арга хэмжээг авахгүй байна.

Худалдааны байгууллагуудын ажиллагаанд оршиж байгаа үндсэн дутагдлуудыг дурдвал:

Худалдааны Нам ба Хоршоодын Төв Холбооны харьяа худалдааны газрууд, нарийн тодорхойгоор жигд ажиллахгүй байна. Увс

Зөвхөн зэргийн бусад олон аймагт худалдааны газруудыг буруугаар байрлуулжээ. Барааг хувиарлах ба татаж авахдаа ард олны эрэлт хүсэлт болон аймгуудын онцлог байдлыг харгалздаггүй, дур зоригоор хийдэг, мөн дамжлагын базууд ба складуудад хүрэлцэх хэмжээний бараа байсаар атал ард түмнийг тэргүүн хэрэгцээний бараагаар хангах явдалд үргэлж тасалдлыг гаргаж байна.

Барааг үйлдвэрлэн гаргах төлөвлөгөөг цаг тухайд нь биелүүлэх, үйлдэхүүний нэр төрлийг өргөтгөх, чанарыг дээшлүүлэх талаар худалдааны байгууллагуудаас орон нутгийн үйлдвэрт идэвхтэй нөлөөг үзүүлэхгүй байна. Гар Үйлдвэрийн Төв Зөвлөл, Аж Үйлдвэрийн Яам, Хүнсний Үйлдвэрийн Яамны харьяа үйлдвэрүүдээс ард олонд худалдаагдахад зориулан, чанаргүй эдлэлийг нийлүүлж байхад түүнтэй эвлэрэн сууж байдаг явдал худалдааны ажилтан нарын дотор одоо хүртэл арилаггүй нь дээн ч тэсвэрлэшгүй юм.

Нийтийн хоолны газруудын ажил, байнга өсч байгаа шаардлагаас сүрхий хоцорч, зарим том суурин газар ба автомашин, төмөр замын дагуу буудлуудад гуанз, зуушны газрууд байхгүй байна. Хотууд ба хөдөө орон нутагт байгаа ресторан, гуанз, зуушны газар, буфетүүдэд янз бүрийн, сайн чанарын хоолыг хийж чаддаггүй, хүмүүсийг боловсноор үйлчилдэггүй, ариун дэврийн байдал муу, хоолыг зөвөөр үнэддэггүй, мөн хоолыг тавьглах норм байхгүй байна.

Худалдааны байгууллагууд, боловсон худалдааны төлөө байнгын тэмцлийг хийдэггүй байна. Хот хөдөөгийн дэлгүүрүүдэд зарим худалдагчид ба худалдааны бусад ажилтнаас хүмүүстэй бүдүүлгээр харилцдаг, ариун цэврийг сэхиддэггүй, барааг дэлгүүрийн тавиур ба шилтэй лангуунд буруу тавьдаг байна.

Худалдааны Яам, Хоршоодын Төв Холбооны системд улсын ба хоршооллын өмчийг хамгаалах ажил хангалтгүй зохиогдож байна. Төйлөн, бүртгэлийн дүрэм журмыг зөрчих, склад ба дэлгүүрүүдэд барааг гэмтээх, мөнгөн ба эд материалын

үнэт зүйлүүдийг хулгайлэн шамшигдуулах явдал цөөнгүй байна.

Эдгээр бүх дутагдал бол юуны өмнө улсын ба хоршооллын худалдааг эрхэлсэн төв, орон нутгийн байгууллагуудын зүгээс анхны хоршоо, дэлгүүр, нийтийн хоолны газруудын ажиллагаанд тавих хяналтаа сулруулан, зохион байгуулалтын амьд ажлыг орхигдуулснаар тайлбарлагдана.

Эд хэрэглэгчдийн хоршооллын байгууллагууд нь хоршоодын ажил ба худалдаанд хяналт тавих талаар хувь нийлүүлэгчдийг идэвхтэй оролцуулах ажлыг дутагдалтай хийж байна.

Худалдааны Яам ба Хоршоодын Төв Холбооны харьяа байгууллагууд нь худалдааны байгууллагуудын ажлын нэн чухал асуудал болсон дэлгүүр, гуанзуудын шилдэг ажилтан нарын тэргүүний туршлагыг нэгтгэн дүгнэх, дэлгэрүүлэх явдлыг туйлын хангалтгүй анхаарч байна.

Аймаг, хотын хөдөлмөрчдийн депутатуудын хурлуудын гүйцэтгэх захиргаад ба намын байгууллагууд, худалдааны байгууллагуудын ажлыг дутагдалтай удирдаж, тэдгээрийн ажлыг ард олны дотор худалдааг цэгцэтгэн зохиох үндсэн асуудлуудад чиглүүлэхгүй байна. Үүний уршгаар худалдааны ажилтан нарын дунд явуулах зохион байгуулалтын амьд ажлыг бичиг бичиж, хүнд суртлаар удирдах аргаар сольдог нь маш олон байна.

Улсын ба хоршооллын худалдааг цаашид сайжруулан хөгжүүлэх зорилгоор Б.Н.М.А. Улсын Сайд нарын Зөвлөл ба М.А.Х. Намын Төв Хорооноос Т О Г Т О О Х нь:

I. Энэ тогтоолд тэмдэглэсэн дутагдлуудыг арилгаж, худалдааны бүх ажилтан нарын ажлыг сайжруулан, юуны өмнө ард олныг бараагаар тасалдуулалгүй хангаж байх, нийтийн хоолны газруудын ажлыг эрс сайжруулах, боловсон худалдааг өрнүүлэх, улсын ба хоршооллын өмчийг хамгаалахын төлөө тэмцэх зорилтыг Худалдааны Яам, Хоршоодын Төв Холбоо ба тэдгээрийн харьяа орон нутгийн байгууллагуудын өмнө

тавьсугай.

2. Бараа гүйлгээний талбар:

а/ Хүнсний ба аж үйлдвэрийн барааг ард олонд худалдаалах ажлыг ихэд нэмэгдү үлэх зорилгоор 1955 оны улсын төлөвлөгөөнд барааны зах зээлийн фондыг 1954 оныхоос 10 %-иас доошгүйгээр нэмэгдүүлэх ба тэрчлэн додоодын аж үйлдвэрээс боловсруулах гаргаж байгаа гэрийн эсгий/эсгий гутал, ажлын савхин гутал, булчгаар, сур, дээс, шүдэнз, талх, нарийн боов, лавшаа, гоймон, пүнтүүз, колбасаны зүйл, аж ахуйн ба гар нүүрийн савангийн үйлдвэрлэлийг ихэд нэмэгдүүлэхээр бодож оруулсугай;

б/ Гар үйлдвэрийн хоршооллын артелиудаас үйлдвэрлэн гаргаж байгаа ардын хэрэгцээт барааны 30 % хүртлэхийг 1955 оны I дүгээр сарын I-нээс эхлэн, улсын худалдаа ба эд хэрэглэгчдийн хоршоонд шилжүүлж байхыг Гар Үйлдвэрийн Төв Зөвлөлд ү-үрэг болгосугай.

Улсын худалдаа ба Хоршоодын Төв Холбооны харьяа худалдааны байгууллагуудад барааг нийлүүлэхдээ батлагдсан жижиглэн худалдаалах үнээс нь худалдааны хорогдлыг хэсгээд, гарцхүү тэдгээртэй зөвшөөрөлцсөн нэр төрөл, үлгэр маяг ба хэмжээгээр нь нийлүүлж байсугай.

Худалдааны байгууллагууд нь батлагдсан үлгэр маягийн ёсоор хийгээгүй муу чанарын барааг худалдаанд н-аргахгүй байхын тулд гар үйлдвэрийн хоршооллын артелиудаас ард түмэнд хэрэгцээтэй сайн чанарын барааг хүлээн авах явдалд хатуу хяналтыг төвж байсугай;

в/ 1955 оны I дүгээр улирлээс эхлэн, худалдааны бүх байгууллага нь талх, нарийн боов, колбаса, архи-дарсны зүйл ба мөн гутал, бэлэн хувцас зэргийг үйлдвэрлэдэг аж үйлдвэрийн газруудад улирлын захиалагыг өгч байх системд орж ажилласугай.

Залуу Барааг
Авах

Худалдааны
байгууллагаас
Улирлын
Захиалгыг
Өгч Авах

5/

Дотоодын үйлдвэрүүдээс боловсруулж байгаа барааны нэр төрлийг тогтмол хянан үзэж, хэрэгцээ^{гүй} барааг үйлдвэрлэлээс хасах ба шилдэг сайн барааг үйлдвэрлэхээр төлөвлөж байх тухай саналээ тавьж байсугай;

г/ Дэмжлэг баазуудын ажлыг сайжруулж, аж үйлдвэрээс сайн чанарын барааг хүлээн авч байх ба мөн хэмжээ, үлгэр маяг, өнгө, нэр төрлөөр нь ялгасан барааг тээвэрлэлтийн нөхцөл байдалд тохирох бэглээ боодолтойгоор худалдааны байгууллагуудад тавьж олгох ба ачуулж байх талаар уул баазуудын хариуцлагыг дээшлүүлэхийг Худалдааны Яаманд үүрэг болгосугай;

д/ Дотоодын аж үйлдвэрүүдээс барааг нийлү-үлэх үндсэн нөхцөлүүдийг 1955 оны I дүгээр сарын I-нээс эхлэн, дагаж мөрдөхийн тулд, уул нөхцөлүүдийг 3 сарын дотор боловсруулж, Сайд нарын Зөвлөлд батлуулахаар оруулахыг Худалдааны Яам, Хоршоодын Төв Холбооны Ерөнхий Хороо, Аж Үйлдвэрийн Яам, Хүнсний Үйлдвэрийн Яам, Гар Үйлдвэрийн Төв Зөвлөлд үүрэг болгосугай;

е/ Орон нутгийн худалдааны байгууллагуудын зохиолго ба ард түмний эрэлт хүсэлтийн судалгааны тоо баримтууд, мөн аймгуудын үндэстний ба ахуй байдлын нөхцлүүд, улирлын хэрэгцээ, барааны үндэгдэл зэрэг бусад онцлог байдлыг заавал хэргэлзэн үзсэний үндсэн дээр ардын хэрэгцээт барааг татаж авах ба үйлдвэрлэн гаргахээр төлөвлөж байхыг Худалдааны ба төлөвлөгөөний бүх байгууллагад дээшлгасугай;

ё/ Соёлын бараа, сургуулийн ба бийгийн хэрэгсэл, радио, барааг 1954 оны 10 дугаар сарын I-нээс эхлэн, өргөнөөр худалдаалахыг Худалдааны Яам ба Хоршоодын Төв Холбоонд үүрэг болгосугай. Энэ зорилгоор Улаанбаатар хотын хэд хэдэн дэлгүүр ба аймгийн төвийн дэлгүүрүүдэд эдгээр барааг худалдаалах тусгай тасгуудыг байгуулж ажиллуулсугай. Соёлын бараа, радио бараа, цахилгаан барааг худалдаалах тусгай дэлгүүрийг 1955 онд Улаанбаатар хотонд нээн байгуулсугай;

Соёлын бараа,
радио, бараа,
цахилгаан

г/Улаанбаатар хотын 5 том дэлгүүрт гурил, будаа, сахарыг гагцхүү тусгай боодолтойгоор худалдаалах ахлыг 1954 оны 4 дүгээр улирлаас эхлэн зохлох, цаашид ийм журмаар худалдаалах явдлыг хотын худалдаа ба төмөр замын худалдааны бусад дэлгүүрт өргөтгөхийг Худалдааны Наманд-үүрэг болгосугай. Энэ зорилгоор боох аппаратыг захлалан ирүүлж, боодлын хүүдийг бэлтгэсүгэй;

д/Чойбалсан, Сүхбаатар, Цэцэрлэг, Ховд хотуудын дэлгүүрүүдэд будаа, сахарыг 1955 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн, боодолтойгоор худалдаалах ажилд шилжин орохыг Хоршоодын Төв Холбоонд үүрэг болгосугай.

е/Барааны тээвэрлэлтийг түргэтгэх, тээврийн ба бусад зардлыг хасардуулах зорилгоор барааг дамжлага базуудаас аймгийн холбоодын складад татан авдаг явдлыг 1954 оны 4 дүгээр улирлаас эхлэн эрс багасгах, барааг нэр төрлөөр нь ачуулах зарчмыг хатуу баримтлан, барааг анхны хоршоодод шууд татаж авах явдлыг өргөтгөхийг Хоршоодын Төв Холбоонд үүрэг болгосугай;

ж/Улсын анхиглэн худалдаалах үнийг худалдааны байгууллагуудад сахин биелүүлж бий эсэх явдалд тавих хяналтыг хүчтэй болгох зорилгоор хүнсний ба аж үйлдвэрийн үндсэн барааны үнийн преysкурантыг I сарын дотор олон хувиар хэвлүүлж, бүх дэлгүүр, мужлаг, худалдааны аген-туудад хүргүүлэн өлгүүлэхийг Худалдааны Нам ба Хоршоод-ны Төв Холбоонд үүрэг болгосугай.

Хүнсний ба аж үйлдвэрийн бүх төрлийн барааны одоогийн дараах байгаа анхиглэн худалдаалах үнийн бүрэн рейскурантыг 6 сарын дотор эмхтгэж, хэвлүүлэхийг Худал-

7/

дааны Яаманд даалгасугай;

д/ Улсын ба хоршооллын худалдааны байгууллагуудын жижиглэн худалдаалах ажлын дүрэм, мөн дэлгүүр, мухлаг, агент, гуанз, ресторануудад ааваал байвал зохих бэрээни нэр төрлийн доод хэмжээ, түүнчлэн дэлгүүр, мухлагийн эрхлэгч нарын эрх, үүргийн тухай дүрмийг 1955 оны 1 дүгээр сарын 1-ний нээнэ бөтлөөд, дагаж шийтгүүлэхийг Худалдааны Яам, Хоршоодын Төв Холбоонд үүрэг болгосугай.

Худалдаалах ажлын дүрэм ба бэрээни нэр төрлийн доод хэмжээг олон хувиар хэвлэж, дэлгүүр, мухлаг бүрд ил тод газарт өлгөсугай.

3. Нийтийн хоолыг сайжруулах талаар:

Нийтийн хоолны зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор:

а/ 1954 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн, халуун, хүйтэн хоолны газруудыг хөдөөд бол Хүнсийн Үйлдвэрийн Яамны мэдлээс Хоршоодын Төв Холбооны системд шилжүүлэх, харин Улаанбаатар хотод бол яамд ба элбэн газруудын мэдлээс Худалдааны Яамны системд шилжүүлэн ажлуулсугай;

б/ Нийтийн хоолны газруудыг тасралтгүй ажиллуулахын тулд мах, ногоо зэрэг зүйлүүдийг цаг тухайд нь

улирлаар бэлтгэж, тэдгээрийг удаан хугацаагаар хадгалж байх явдлыг хангахыг Худалдааны Яам ба Хоршоодын Төв Холбоонд үүрэг болгосугай.

в/Хотын доторхи гуанз, ресторануудын ажлыг сайжруулах, боловсон үйлчилгээ ба ариун цэврийн байдлыг дээшлүүлэх, хоолны нэр төрлийг өргөтгөн, хоолны амт чанар ба үзэмжийг сайжруулах, дээд сургууль, техникум, бусад сургуулиудын дэрэгдэх оюутан, сурагчдын гуанз, буфетуудын ажлыг журамтай болгож, хоол ундыг оюутан, сурагчдад тохирсон үнээр бэлтгүүлж байхыг Худалдааны Яаманд даалгасугай.

Мөн хөдөлмөрчдийг сайнаар бэлтгэсэн амттай хоол, ундаар түргэн хангаж чадах хүйтэн хоолны боловсон тохилог газруудыг хот ба аймгийн төвүүдэд өргөтгөн байгуулсугай.

г/Хоолны калькуляцыг журамтай болгох, үйлдэхүүнийг тавагт хийх рецептур-нормыг тогтоох талаар 3 сарын дотор зохистой арга хэмжээнүүдийг авч, хоол бэлтгэх технологид холбогдсон практик хэрэглэгдэхүүнээр гуанз, ресторануудыг хангасугай.

д/Гуанз, ресторануудын дэргэд тэдгээрийн хаягдал хоолоор гахай тэжээх, шувуу өсгөх ажлыг 5 зохиосугай.

4. Худалдааны газруудыг өргөтгөн хөгжүүлэх талаар:

Хот ба хөдөөд одоогийн ажиллаж байгаа худалдааны газруудыг өргөтгөн олшруулах явдлын чухлыг харгалзан, дор дурдсан арга хэмжээнүүдийг авах нь чухал гэж үзсүгэй.

Худалдааны Яамны талаар 1954-56 онуудад дор дурдсан газруудыг нээн байгуулсугай:

а/Налайх ба Толгойтод төрөл бүрийн барааны дэлгүүр тус бүр 1, Аж Үйлдвэрийн комбинатад хүнсний барааны дэлгүүр 1, хотын төвд мах, сүү, соёлын барааны дэлгүүр, тус бүр 1, мөн хүүхдийн универмаг 1, ногооны дэлгүүр 3, янз бүрийн талхны дэлгүүр 3, бүгд 13 дэлгүүрийг хотын элдэв районд нээсүгэй.

б/Хотын элдэв районд бүрэн төхөөрөмжтэй гуанз 4-ийг шинээр нээн байгуулсугай.

в/Улаанбаатар хот ба төмөр замын станцуудад боодлын ба жижиг-ширхгийн бараа, янз бүрийн жижиг бараа, ном хэвлэл, ус, пиво, архи-дарсны зүйлийг суурин худалдаа даалж байх бүхээг-мухлагуудыг өргөтгөн олшруулсугай.

Цэвэр хийцтэй модон бүхээг-мухлаг 20-ыг 1955 оны 7 дугаар сарын 1-ний наана шинээр нэмэн байгуулахыг Худалдааны Яаманд даалгасугай.

Өдгээр бүхээг-мухлагийн барилгыг гагцхүү Архитектур-төлөвлөгөөний газраас боловсруулан баталсан нэгэн маягийн зураг, төлөвлөгөөний ёсоор бариулахаар тогтоосугай.

г/Түргэн муудаж гэмтдэг барааг хадгалах янз бүрийн багтаамжтай склад-зойруудыг Монгол Гадаад Худалдааны газрын харьяа бүх дамжлага ^{базуудад} бариулсугай. Үүний дотор 1955 онд Төв бараа базад 300 тоннын багтаамжтай склад 1-ийг бариулж, түүнийг ачих-буулгах, өргөх механизмуудаар төхөөрөмжлөх ба мөн Хотын худалдааны трестэд 500 тоннын багтаамжтай ногооны зойр 1-ийг бариулж дуусгасугай.

д/Түргэн муудаж гэмтдэг хүнсний барааг хадгалахад зориулж, тус бүр 5 тонн хүртэл багтаамжтай

энгийн хүйтэн зойруудыг томхон дэлгүүр ба гуанзуудын дэргэд бариулсугай.

Хоршоодын Төв Холбооны талаар 1954-56 онуудад дор дурдсан газруудыг байгуулсугай:

е/Чойбалсан, Завхан, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь аймгуудын төвд нэг маягийн универмагуудыг байгуулсугай.

ё/Анхны хоршоодод суурин дэлгүүргүй ба барааны складгүй бүх сумдад тэдгээрийг нэг маягийн зураг, төлөвлөгөөгөөр байгуулсугай.

Говийн аймгуудын сумдад дэлгүүр, складуудыг байгуулахад зориулж, стандартын угсармал байшин 20-оос доошгүйг ба мөн аймгуудаас мал туугчдыг мал тууврын зам дагуу болон тэрчлэн улсын аж ахуйнуудын ажилчин, албан хаагчдыг худалдаагаар үйлчилж байхад зориулж, авто-мухлаг 15-аас доошгүйг 1955-56 онуудад тус тус захиалан ирүүлэхийг Худалдааны Яаманд үүрэг болгосугай.

Аймгийн холбоод, анхны хоршоод ба улсын аж ахуйнуудад зориулж, нэг маягийн дэлгүүр, гуанз, хүйтэн зойр, склад, талх барих газруудыг бариулах зураг, төсвийг 3 сарын дотор боловсруулан гаргахыг Архитектур-төлөвлөгөөний газарт даалгасугай.

5. Худалдааны байгууллагуудад боловсон хүчнийг бэлтгэх талаар:

а/Боловсон хүчин-мэрэгжилтэн нарыг шууд худалдааны ажил дээр бэхжүүлэн, боловсон хүчнийг дээд, дунд сургууль, курсүүдээр дамжуулан бэлтгэх ажлыг сайжруулахыг Худалдааны Яам, Хоршоодын Төв Холбоонд

даалгасугай.

✓ б/Худалдааны ажилтан нар ба дамжлага базуудын мэрэгжилтэн нарын мэрэгжлийг дээшлүүлж байхын тулд жил дутам 100-аас цөөнгүй хүнийг сургах байнгын курсийг 1954 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулж, уг курсийн зардлыг Худалдааны Яамны харьяа байгууллагуудын боловсон хүчнийг бэлтгэх шимтгэлээс гаргаж байхыг Худалдааны Яаманд зөвшөөрсүгэй.

✓ в/Аймгийн холбоод ба анхны хоршоодын ажилтан нарын мэрэгжлийг дээшлүүлэхийн тулд жил бүр 200 хүнийг сургах байнгын курсийг 1955 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн, Хоршоодын Төв Холбооны шугамаар Улаанбаатар хотонд байгуулж, түүний зардлыг соёлын фондод оруулдаг шимтгэлээс гаргаж байсугай.

✓ г/Худалдааны ажилтан нарын мэрэгжлийг дээшлүүлэх, худалдааны ажлын тэргүүний туршлагыг нэгтгэн дэлгэрүүлэхийн тулд "Боловсон худалдааны төлөө" гэдэг сэтгүүлийг сар бүр гаргаж байхыг Худалдааны Яам ба Хоршоодын Төв Холбоонд зөвшөөрсүгэй.

Амттай сайхан хоолыг хэрхэн бэлтгэдэг тухай номыг хэвлэн гаргахыг Худалдааны Яаманд даалгасугай.

6. Дотоодын үйлдвэрүүдээс боловсруулж байгаа барааны нэр төрлийг өргөтгөн, чанарыг сайжруулах талаар:

Хүнсний Үйлдвэрийн Яаманд үүрэг болгох нь:

а/Улаанбаатар хот дахь Махкомбинатад үйлдвэрлэж байгаа колбасаны зүйлийн нэр төрлийг өргөтгөж, 1955 онд колбасаны зүйлийг 1954 оны төлөвлөгөөнөөс

20-оос доошгүй хувиар нэмэгдүүлсүгэй.

Сосиск, сердельк, хатуу-утсан ба гахайн утсан колбасаг хотын доторхи худалдааны байгууллагуудад зориулан тасралтгүй үйлдвэрлэж, төрөл бүрийн колбасаг үйлдвэрлэхэд тогтоосон рецентур /жор/-ийг хатуу баримтлан ажилласугай.

б/Талх ба нарийн талхны зүйлийг ард олноос улам ихээр хүсэж байгаа явдлыг харгалзан, хот ба аймгуудад талх болон нарийн талхны чанарыг сайжруулж, хатсан ба хуурай буюу түүхий талхыг худалдаанд гаргах явдлыг зогсоосугай.

Улаанбаатар хот дахь талхны заводыг чухал хэрэглэгдэх төхөөрөмжөөр хангаж, 1954 оны 4 дүгээр улирлаас эхлэн, 1 кг-ын талхны гаргалтыг 2 дахин нэмэгдүүлэн, талхны заводад улаан-буудайн 3-р гурилаар өдөр бүр талх барьдаг болгосугай.

в/Нарийн боовны чанарыг эрс сайжруулж, шинэ нэр төрлийг хийж гаргах ба мөн цаастай чихрийг үзэмжтэй бөгөөд сайн боодолтойгоор үйлдвэрлэн гаргах байсугай.

г/Улаанбаатар хотын ард олонд шинэ ногоо, төмс худалдаалах явдлыг нэмэгдүүлэхийн тулд ногоо, төмсийг 6,7 дугаар сараас эхлэн худалдаалахаар бодож, эрт түргэн ургадаг ногоо, төмсийг тариалах явдалд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг тасралтгүй авч байсугай.

Хотын дэлгүүр, гуанз, ресторануудад зориулан, хүнсний ногоог 1955 оны хавраас эхлэн, дулаалсан аж ахуйд тарьж ургуулдаг болгохын тулд ногооны комбинатад ногоо тарих дулаалсан шил рам тавих тухай асуудлыг

2 сарын дотор боловсруулсугай.

Худалдааны байгууллагууд ба нийтийн хоолны газруудын хэрэгцээт байцаа, помидор, огурцыг ногооны комбинатад давслаж хадгалах ажлыг 1954 оны намраас эхлэн зохиосугай.

д/1954 оны намраас эхлэн, зэрлэг жимсийг улам идэвхтэйгээр бэлтгэн боловсруулж, түүгээр варень, жем ба шүүс хийх явдлыг нэмэгдүүлсугай.

е/Архины заводыд үйлдвэрлэж байгаа дарс, ундны зүйлийн нэр төрлийг өргөтгөж, түүний чанарыг үргэлжлэн дээшлүүлж байсугай.

Улаанбаатар хотын архины заводын бүх гаргаж байгаа архины 20 хувиас доошгүйг 1955 оны 7 дугаар сарын 1-ний наана 0,25 литрийн багтаамжтай шилд а савалдаг болгохоор бодож, тус заводыд архийг 0,25 литрийн багтаамжтай шилд савлах ажилд 1955 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн орсугай.

1954 оны 4 дүгээр улирлаас эхлэн, пивоны заводыд пивоны гаргалтыг нэмэгдүүлэн, чанарыг нь улам сайжруулсугай.

ж/Хөдөөгийн ард түмэнд талх худалдаалах явдлыг нэмэгдүүлэх зорилгоор томхон анхны хоршоодын дэргэд талх барих жижиг газар 50-ыг байгуулж, үүнээс 20-ыг 1955 онд ба 30-ыг 1956 онд тус тус ашиглалтад оруулахыг Хоршоодын Төв Холбооны Ерөнхий Хороонд үүрэг болгосугай.

Талхны газрын барилгыг олон хүн явдаг замын дагуу байгаа ба орон нутагийн түлш, усаар хангагдсан

олон хүнтэй сумдын төвд эхэлж бариулсугай.

ж/Дээрэх талхны газрыг бариулах зураг, төлөвлөгөөг I сарын дотор боловсруулж, тэдгээрийг бариулах талаар Хоршоодын Төв Холбоонд зөвлөлгөө тусламжийг үзүүлэх ба төрчлэн тэдгээр талх барих газарт ажиллах мастер 20-ыг 1955 оны 7 дугаар сарын I-ний наана, мөн мастер 30-ыг 1956 оны 7 дугаар сарын I-ний наана харьяа газруудаараа тус тус бэлтгэн гаргахыг Хүнсний Үйлдвэрийн Яаманд үүрэг болгосугай.

Аж Үйлдвэрийн Яаманд үүрэг болгох нь:

а/1955 онд гэрийн эсгий, эсгий гутал, савхин ба булигаар гутлыг 1954 оныхоос 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлэн үйлдвэрлэж, худалдааны байгууллагад тушаах явдлыг хангасугай.

б/Булигаар, сур, дээс зэрэг ард түмний хэрэгцээт зүйлийн үйлдвэрлэлтийг эрс нэмэгдүүлсүгэй.

в/Савхин гутлын чанарыг байнга сайжруулж, ард түмний хэрэгцээт шинэ хэв маягийн гутлыг үйлдвэрлэн гаргаж байсугай.

Хүүхдийн гутлыг үйлдвэрлэх, мөн зуны ба биеийн тамирын гутлыг улирлаар үйлдвэрлэх явдлыг нэмэгдүүлсүгэй.

г/Хувцас, малгай оёх ба сүлэмэл эдлэлийг үйлдвэрлэх явдлыг өргөтгөж, автомеханик завадад төмөрлөг эдлэлийн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэн, чанарыг нь сайжруулсугай.

д/Ард түмний хэрэгцээгүй бараа үйлдвэрлэх явдлыг зогсоож, түүний оронд худалдааны байгууллагуудын

захиалгаар шинэ зүйлүүдийг үйлдвэрлэн гаргаж байсугай.

7. Хотод ойролцоо байгаа улсын аж ахуй, ардын үйлдвэрлэлийн нэгдлүүдэд сүүний малыг өсгөн, ойрын 2-3 жилд эдгээр аж ахуйгаас сүү худалдаалах явдлыг 3-аас доошгүй дахин нэмэгдүүлж, сүү ба цагаан идээг зөвхөн зуны цагт биш, мөн өвлийн цагт худалдаалж байх бололцоог бий болгохыг Мал Аж Ахуйн Яам, Улсын аж ахуйнуудыг удирдах ерөнхий газарт үүрэг болгосугай.

8. Улсын аж ахуйнуудаас хөдөө аж ахуйн үйлдэхүүнийг хот ба орон нутгийн худалдааны байгууллагуудад нийлүүлэх тухайн нөхцөлүүдийг I сарын дотор баталж, түүний дотор нийлүүлэх зүйлийн нэр төрөл ба хугацаа, улсын аж ахуйнуудаас татаж авах журам, мөн тооцоо хийх журам зэргийн бусад асуудлыг тодорхой зааж тогтоохыг Худалдааны Яам ба Улсын аж ахуйнуудыг удирдах ерөнхий газарт үүрэг болгосугай.

9. Худалдааны зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор дор дурдсан арга хэмжээнүүдийг авах нь чухал гэж үзсүгэй:

а/ Бараа ба түүхий эдийн чанарыг шалгах, худалдааны байгууллагуудын ажилд хяналтыг тавьж байх
Улсын байцаан шалгах газрыг 1955 оны I дүгээр сарын I-нээс эхлэн, Б.Н.М.А. Улсын Худалдааны Яамны дэргэд байгуулсугай.

Бараа ба түүхий эдийн стандарт, кондицийг сахиж бий эсэх, түүхий эдийн хадгалалт ба боловсруулалтыг зөв хийж байгаа эсэхэд хяналтыг тавих, бараанд шинжилгээ/экспертиз/ хийх, мөн баз, дэлгүүр, мухлаг, ресторан,

16/

гуанзүүдээс худалдааны ажлын дүрэм, жижиглэн худалдаалах үнийг сахин биелүүлж бий эсэх, худалдан авагчдад барааг зөв олгож байгаа эсэхэд хянат тавьж байхыг Улсын байцаан шалгах газарт үүрэг болгосугай.

Улсын байцаан шалгах газрын дүрэм ба орон тооны төлөвлөгөөг 2 сарын дотор боловсруулж, Сайд нарын Зөвлөлд батлуулахаар оруулахыг Худалдааны Наманд үүрэг болгосугай.

б/Монгол улсын номын худалдааны газрыг 1955 оны I дүгээр сарын I-нээс эхлэн, Худалдааны Намны мэдэлд шилжүүлсүгэй.

Үүнтэй уялдуулан, хотууд ба аймгуудын Х.Д.Х. Гүйцэтгэх Захиргааны дэргэд 1955 оны I дүгээр сарын I-нээс эхлэн худалдааны хэлтсүүдийг байгуулсугай.

Заавал байлгавал зохих барааны нэр төрлийн доод хэмжээг баримталж бий эсэх, барааг худалдааны газруудад цаг тухайд нь зөвөөр татан авч бий эсэх, жижиглэн худалдаалах үнэ, арвилан хэмнэх ёс, журам, мөн дэлгүүр, мухлаг зэрэг худалдааны байгууллага, нийтийн хоолны газруудын ажиллагааны дүрмийг сахин биелүүлж байгаа эсэх явдалд хяналт тавьж байхыг худалдааны хэлтсүүдэд үүрэг болгосугай.

в/Монгол улсын номын худалдааны газрыг шилжүүлж, мөн аймаг, хотын худалдааны хэлтсүүд ба улсын байцаан шалгах газрыг байгуулсан явдлыг харгалзан, Худалдааны Намны зохион байгуулалтыг энэ оны IO дугаар сарын I-ний наана боловсруулан ирүүлэхийг Худалдааны Наманд үүрэг болгосугай.

г/Улсын аж ахуйнуудад худалдааны ажлыг эрс

сайжруулах зорилгоор улсын аж ахуйнуудад худалдааны ажлыг зохион байгуулах тасгийг 1954 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн, Хоршоодын Төв Холбооны Ерөнхий Хорооны дэргэд байгуулж, улсын аж ахуйнууд дахь худалдааны байгууллагуудыг хоршоодын Төв Холбоонд шууд харьяалуулсугай.

д/Хоршоодын дүрмийг хатуу баримтлах, удирдах ба хянах байгууллагуудын сонгуулийг цаг тухайд нь явуулах, хувь нийлүүлэгчдийн хурлаар тэдний илтгэл тайланг сонсох, шалган байцаах комиссуудын ажилд хувь нийлүүлсэн гишүүдийг идэвхтэй оролцуулах, сонгуулийн ажилтан нар ба мэрэгжилтэн нарыг хууль бусаар ажлаас нь халах, шилжүүлэх явдлыг гаргахгүй байлгахыг Хоршоодын Төв Холбоо, аймгийн хоршоодын холбоо, анхны хоршоодод үүрэг болгосугай.

10. Худалдааны байгууллага, дэлгүүр, гуанэуудын ажилд өдөр дутмын хяналтыг тавьж, боловсон худалдааны зарчмыг газуудуулах явдалтай шийдвэртэй тэмцлийг явуулан, дэлгүүр, гуанэуудын ажилд илэрсэн дутагдлуудыг арилгах талаар арга хэмжээнүүдийг авч, ард олныг үйлчилэх явдлыг тасралтгүй сайжруулж байхыг орон нутгийн улсын ба намын байгууллагуудад үүрэг болгосугай.

Ажилдаа оршиж байгаа дутагдлуудыг богино хугацааны дотор үндсээр нь арилгаж, худалдааны ажлыг энэ талаар нам, засгаас тавьсан зорилтуудын хэмжээнд хүртэл дээшлүүлэхийг Б.Н.М.А. Улсын Сайд

нарын Зөвлөл ба М.А.Х.Намын Төв Хороонсоос
худалдааны байгууллага, нийтийн хоолны газруудын
бүх ажилтанд уриалж байна.

ЕРӨНХИЙ

САЙД

/ЦЭДЭНБАЛ/

НАМЫН ТӨВ ХОРООНЫ 1-р
НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

/ДАМБА/

цохив Дарь, Темер нар.

нийлэв.